

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.ОРШИЛ

Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 4.2.8. “Цахилгаан станцуудыг өргөтгөж, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, шинэ эх үүсвэрийг барьж, цахилгаан эрчим хүчээр дотоодын хэрэгцээг бүрэн хангасан байна”, Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа 4.2.36.”Эрчим хүчний нэгдсэн системийн горим тохируулгын эх үүсвэрийг барьж байгуулан импортын эрчим хүчний хараат байдлыг бууруулна”, 4.2.37. “Сэргээгдэх эрчим хүчний суурилагдсан чадлыг 30 хувьд хүргэх, гадагш урсгалтай гол, мөрний урсцын 10 хувийг эрчим хүчний үйлдвэрлэл болон бусад хэрэгцээнд ашиглана”, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.3.35 “Нэгдсэн сүлжээний горим тохируулах үүрэг бүхий 100 МВт хүртэл хүчин чадал бүхий усан цэнэгт цахилгаан станц барина.”, Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.3.3-д “Нар, салхины сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг төр, хувийн хэвшил, оролцоотойгоор хэрэгжүүлж, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлнэ” гэж тус тус заасан байна.

Эдгээр зорилтуудтай уялдуулан Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын төвөөс 46 км, Багануур дүүргээс зүүн урд зүгт 16 км зайд байрлах Бүрэн ууланд Хэрлэн голын ойролцоо байрлах “Нэгдсэн сүлжээний горим тохируулах үүрэг бүхий 100 МВт хүртэл хүчин чадал бүхий усан цэнэгт цахилгаан станцын төслийг Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийг танилцуулж байна. Уг төслийг Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх нь урт хугацааны гэрээгээр улсын төсөвт ачаалалгүйгээр хэрэгжинэ.

Уг түншлэлийн төсөл нь нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээний салбарт хэрэгжүүлэх, олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн, олон нийтэд үйлчлэх зорилгыг дэмжсэн байх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төсөв, санхүүгийн удирдлагад хяналт, зохицуулалтын тэнцвэрийг хангаж, хувийн хэвшилд суурилсан эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн байх түншлэлийн зарчимд нийцсэн болно.

Нэгдсэн сүлжээний горим тохируулах үүрэг бүхий 100 МВт хүртэл хүчин чадал бүхий усан цэнэгт цахилгаан станцын төслийн нийт хөрөнгө оруулалт 544.3 тэрбум төгрөг (151.9 сая ам.доллар) / Монгол банкны 2025.07.05-ны өдрийн ханш 3583.6 төгрөг / байна. Төслийг 18 жилийн хугацаанд хийж гүйцэтгэх ба үүнээс бүтээн байгуулалт 2026-2028 онд буюу 3 жилийн хугацаанд гүйцэтгэнэ. Ашиглалт үйлчилгээ 2029-2043 онд буюу 15 жилийн хугацаатай байна.

Эрчим хүчний хэрэглээний өсөлт жил бүр өсөн нэмэгдэж өвлийн ачааллын үеэр эрчим хүчний хязгаарлалтад орох хүндрэл үүсэж байгаа тул суурь болон горим тохируулгад ажиллах эх үүсвэрүүд ойрын хугацаанд ашиглалтад оруулах хэрэгцээ гарч байна. Тус усан хуримтлуурт усан цахилгаан станц нь ашиглалтад орсноор жилд 292 сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж төвийн бүсийн эрчим хүчний системд нийлүүлэх бөгөөд жил бүр өсөн нэмэгдэж байгаа импортын эрчим хүчний хэмжээг бууруулахаар төлөвлөгдсөн.

1.1 Төрийн түншлэгч

Нэгдсэн сүлжээний горим тохируулах үүрэг бүхий 100 МВт хүртэл хүчин чадал бүхий усан цэнэгт цахилгаан станцын төслийг хэрэгжүүлэх төрийн түншлэгч төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 10.1.9-ын дагуу түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд төрийн түншлэгчийн чиг үүргийг энэ хууль болон гэрээнд зааснаар хэрэгжүүлэх, төслийн хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах асуудлыг Эрчим хүчний яам байна. Тус хуулийн 8.1.6. түншлэлийн гэрээний хэлэлцээрт оролцох, түншлэлийн гэрээг төрийн түншлэгч талыг төлөөлж салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран байгуулах асуудлыг Эдийн засаг, хөгжлийн яам хариуцна.

2.ТҮНШЛЭЛИЙН ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ

2.1 Төслийн нэр

Төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх “Нэгдсэн сүлжээний горим тохируулах үүрэг бүхий усан цэнэгт цахилгаан станцын төсөл” Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын төвөөс 46 км, Багануур дүүргээс зүүн урд зүгт 16 км зайд байрлах Бүрэн ууланд Хэрлэн голын ойролцоо байрлах орон нутгийн тусгай хэрэгцээний газарт байрлахаар төлөвлөгдсөн байна.

2.2 Төслийн төсөв, түншлэлийн гол нөхцөл

Төслийн нийт хөрөнгө оруулалт нь 544.3 тэрбум төгрөг (151.9 сая ам.доллар) байна. Хөрөнгө оруулалтын хувьд 90%-ийг зээлээр, 10%-ийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх боломжтой гэж үзсэн. Энэхүү төсөл нь бүрэн ТЭЗҮ-гүй бөгөөд бүрэн шинжилгээний шатанд анхны хөрөнгө оруулалтын хэмжээ өөрчлөгдөх боломжтой.

2.3 Хувийн хэвшлийн үзүүлэх үйлчилгээ

Хувийн хэвшил нь өөрийн хөрөнгө оруулалтаар Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын төвөөс 46 км, Багануур дүүргээс зүүн урд зүгт 16 км зайд байрлах Бүрэн ууланд Хэрлэн голын ойролцоо байрлах орон нутгийн тусгай хэрэгцээний газарт байрлахаар тодорхойлогдсон бөгөөд 2026-2028 он буюу 3 жилийн хугацаанд хийж гүйцэтгэнэ. Ашиглалт үйлчилгээний тухайд 2029-2043 он буюу 15 жилийн хугацаанд ашиглаж үйл ажиллагааг явуулна.

2.4 Түншлэлийн төслөөр бий болох гол хүчин зүйлс

Эдийн засгийн нөлөөлөл: Импортын цахилгаан эрчим хүчний тодорхой хувийг орлоно. Монгол Улсад ус хуримтлуурт усан цахилгаан станцын төслүүдийн судалгаа хийгдэж байсан боловч одоогоор ашиглалтад орсон төсөл байхгүй байна. Ашиглалтад орсноор эрчим хүчний салбарын технологи, инновацын хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ. Татвар хураамж, төлбөрийн талаар 18.2 сая ам.доллар буюу 65.2 тэрбум төгрөгийн судалгаа байна. /Монгол банкны 2025.07.05-ны өдрийн ханш 3583.6 төгрөг/ Дотоодын үйлдвэрлэлийг дэмжинэ. Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

Төслийн нийгмийн ач холбогдол:

Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр буюу ус хуримтлуурт цахилгаан станц нь нийгмийн болон иргэдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөлөлгүй.

Станц ашиглалтад орсноор:

1. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх ач холбогдолтой.
 2. Барилга байгууламжийн бүтээн байгуулалт, үйл ажиллагааны талаарх мэдлэг туршлагатай болно.
 3. Ажлын байр нэмэгдүүлнэ.
 4. Үйлдвэрлэл хөгжиж, ажилгүйдэл буурах, хүн амын ахуй амьдралыг сайжруулах боломжтой.
 5. Уур амьсгалын хуурайшилт, орчны тоосжилтыг бууруулах, бичил уур амьсгал үүсгэх зэргээр байгаль орчинд ээлтэй.
 6. Эрчим хүчний салбарын технологи, инновацын хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ.
 7. Эрчим хүчний хэрэглээний өсөлтийг хангахад тодорхой хувь нэмрийг оруулна.
- Төслийн бүрэн шинжилгээний үе шатанд ундны усны нөөц, бэлчээрийн хүртээмжид үзүүлэх нөлөөллийн талаар нарийвчлан судлах шаардлагатай.